



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/569

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хөдөлмөрийн тухай хууль болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль, журам, дүрэм, стандартыг олон нийтэд сурталчлах, аюулгүй орчинд хөдөлмөр эрхлэх, эрүүл мэндээ хамгаалах дадлыг олгох зорилгоор агентлаг байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг зохион байгуулахад 3,945,000 (Гурван сая есөн зуун дөчин таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Сургалтыг зохион байгуулахад зарцуулах 3,945,000 (Гурван сая есөн зуун дөчин таван мянга) төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийн бодлого удирдлага хөтөлбөрийн Хөдөлмөрийн хамтын гэрээ хэлэлцээрийг бүртгэж, үйл ажиллагааг дэмжих арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тус чадавхжуулах сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, тайланг хугацаанд нь нэгтгэж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Д.Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

